



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2009 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/1998

Мандалговь

Чанарын удирдлагын хорооны  
бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Засгийн газрын 2008 оны 265 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газарт “Чанарын удирдлагын тогтолцоо” ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх, стандартын тогтвортой байдлыг хангаж ажиллах “Чанарын удирдлагын хороо”-г дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Чанарын удирдлагын хорооны дарга: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Нарийн бичиг:

- Дотоод ажил, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн

2. ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, стандартын хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангаж ажиллахыг Чанарын удирдлагын хорооны даргад даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/147 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100017